



МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ХӨГЖИЛ,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 27 өдөр

Дугаар АН52

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Хүүхэд харах үйлчилгээг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу зохион байгуулж, үйлчилгээ эрхлэгчдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хүүхдийн төлөө үндэсний газар /И.Нарантуяа/-т даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Амарсайхан/, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Одбаяр/-т тус тус үүрэг болгосугай.



081396

Хүн амын хөгжил, нийгмийн  
хамгааллын сайдын 2015 оны 11  
дүгээр сарын 27 өдрийн дугаар  
тушаалын хэвсрэлт



## ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүүхэд харах үйлчилгээнд зөвшөөрөл олгох болон үйлчилгээ эрхлэгчийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, үйлчилгээ эрхлэх шалгуур, болзол, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, түүнд хяналт тавихад энэхүү журмыг баримтлана.

1.2. Энэхүү журам нь төрийн өмчийн болон хувийн цэцэрлэгт үйлчлэхгүй.

### Хоёр. Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол

2.1. Хүүхэд харах үйлчилгээний орон сууц, байшин барилга, өрөө танхим, гэрийн гадаад, дотоод орчин нь "Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандарт"-д нийцсэн байна.

2.2. Хүүхэд харагч нь бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой, хүүхэд харах үйлчилгээний тусгай сургалтад хамрагдаж гэрчилгээ авах ба сум, дүүргийн Засаг даргаас хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан байна.

2.3. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх иргэнд гэрчилгээ олгох сургалтыг Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

### Гурав. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэхээр хүсэлт гаргасан иргэний бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага

3.1. Хүүхэд харах үйлчилгээг эрхлэхээр Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 6.4-т заасан иргэн хүсэлт гаргахдаа дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ.

3.1.1. хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл;

3.1.2. боловсролын диплом, гэрчилгээний эх буюу тэдгээрийн нотаритаар баталгаажуулсан хувь;

3.1.3. хүүхэд харах үйлчилгээний тусгай сургалтад хамрагдаж, бага насны хүүхэдтэй харилцах арга зүй эзэмшсэнийг нотлох гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хувь;

3.1.4. гэмт хэрэгт холбогдож байгаагүйг нотолсон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

3.1.5. халдварт болон сэтгэцийн өвчингүйг тодорхойлсон эмнэлгийн байгууллагын дүгнэлт;

3.1.6. үүсгэн байгуулагчийн өөрийн өмчлөлийн байр, түрээсийн байр, зээлийн байр, гэр болохыг нотолсон Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хувь;

3.1.7. хүүхэд харах үйлчилгээний гадаад, дотоод орчин нь "Хүүхэд харах үйлчилгээний нийтлэг шаардлага, стандарт"-ыг хангасан эсэхэд баг, хорооны Засаг дарга дүгнэлт гаргана.

3.1.8. баг, хорооны Засаг дарга дүгнэлт гаргахдаа Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан ажилтан, нийгмийн ажилтан, эцэг эхийн төлөөлөл бүхий баг ажиллуулж, түүний гаргасан санал, дүгнэлтийг үндэслэл болгоно.

### **Дөрөв. Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах**

4.1. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан нэг хүүхэд харагчид ногдох хүүхдийн тоо тав байна.

4.2. Хүүхэд харах үйлчилгээний нэг байранд хамрагдах хүүхдийн тооны дээд хязгаар 15 байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэгэн адил байна.

4.3. Сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эцэг эх, асран хамгаалагчид өөрийн 2-5 насны хоёр хүртэлх хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулж болно.

4.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нас харгалзахгүйгээр хүүхэд харах үйлчилгээнд хамруулах бөгөөд холимог хэлбэрээр хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэгээс илүүгүй байна.

4.5. Хүүхэд харах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дагнан хамруулах тохиолдолд энэ чиглэлээр мэргэшсэн хүн ажиллах бөгөөд нэг хүүхэд харагчид ноогдох хүүхдийн тоо гураваас илүүгүй байна.

4.6. Хүүхэд харагч нь сайн дурын үндсэн дээр дэмжин туслагч авч ажиллуулж болно.



4.7. Хүүхэд харагч нь тус журмын 4.6-д заасан этгээдийг авч ажиллуулсан тохиолдолд аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад заавал мэдэгдэнэ.

4.8. Хүүхэд харах үйлчилгээний ажиллах цагийн хуваарь нь хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийн ажлын цаг, үйлчлүүлэх хэрэгцээнд нийцсэн байна.

4.8.1. хүүхэд харах үйлчилгээний ажлын цаг нь өдөрт найман цаг байх боловч эцэг эх, асран хамгаалагчтай харилцан тохиролцсон тохиолдолд илүү цагаар ажиллаж болно.

4.8.2. илүү цагийн төлбөрийг эцэг эх асран хамгаалагчидтай харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтооно.

4.8.3. эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн ирцийн бүртгэлийн дэвтэрт өглөө хүүхдээ хүлээлгэн өгөх, орой хүлээн авах бүртээ гарын үсэг заавал зурж баталгаажуулна.

#### **Тав. Хүүхэд харах үйлчилгээнд эцэг эхээс авах төлбөр**

5.1. Эцэг эх, асран хамгаалагч нь нэмэлт төлбөр төлж болно.

5.2. Эцэг эх, асран хамгаалагчийн сард төлөх нэмэлт төлбөрийн дээд хэмжээ хоолны болон нормативт зардлын нийлбэрийн 60 хувиас хэтрэхгүй байна.

#### **Зургаа. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч, эцэг эх, төрийн захиргааны байгууллагын үүрэг**

6.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэг:

6.1.1. хүүхэд харах үйлчилгээ эрхлэж буй иргэдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

6.1.2. үйл ажиллагаа эрхлэх явцад байнгын хяналт тавих

6.2. Хүүхэд харагчийн үүрэг:

6.2.1. хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;

6.2.2. ямарч нөхцөлд хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх;

6.2.3. хүүхдийг сэтгэл зүйн болон бие махбодийн хүчирхийлэл, үл хайхрах явдалд өртүүлэхгүй байх;

6.2.4. хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагаа хийхгүй байх;

6.2.5. холбогдох хууль, дүрэм журам, стандартыг мөрдөх;

6.3. Эцэг, эхийн үүрэг:

- 6.3.1. хүүхдээ эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах;
- 6.3.2. хүүхэд харагчтай хамтарч ажиллах;
- 6.3.3. хүүхдийн ирцийн дэвтрийг тогтмол хөтлөх;
- 6.3.4. хүүхэд харах үйлчилгээний явцад байнга хяналт тавих;

**Долоо. Хүүхэд харах үйлчилгээний хяналт**

7.1. Төрийн байгууллагын зүгээс тавих хяналт

7.1.1. Мэргэжлийн хяналтын байгууллага, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, баг хорооны Засаг дарга нь хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандартыг хангаж байгаа эсэхэд хамтран хяналт тавина;

7.1.2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын ажилтан, сум хорооны нийгмийн ажилтан нь хүүхдийн эрхийн хэрэгжилт, Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журам, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина;

7.2. Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс тавих хяналт

7.2.1. хүүхэд харагч нь хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл болон гэрчилгээг эрх бүхий байгууллагаас авсан эсэх;

7.2.2. хүүхдийн аюулгүй байдал, хоол, хүнс, үйлчилгээний чанарт;

7.2.3. хүүхдийн ирцийн бүртгэлийн дэвтэр болон санал хүсэлтийн дэвтэртэй эсэхэд;

7.2.4. хүүхэдтэй ажиллаж буй арга барил, харилцааны соёл, зан байдалд;

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**